

## ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН 2021 ОНЫ 3 ДУГААР САРЫН ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ

### НЭГ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХҮРЭЭНД

Аймгийн Удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнийг 3 удаа зохион байгуулж, нийт 9 үүрэг даалгавар өгч, хэрэгжилтийг ханган ажилласан.

2021 оны 3 дугаар сарын 25-ны өдөр аймгийн Засаг даргын дэргэдэх агентлаг, соёл урлагийн байгууллага, Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дарга нартай хамтран ажиллах гэрээ, гүйцэтгэлийн төлөвлөгөө батлах арга хэмжээг зохион байгууллаа.

2021 оныг “Нийтийн эрүүл мэндийг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан байгууллагын удирдлагуудад аймгийн Засаг даргаас иргэдийнхээ эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, иргэдэд боловсрол, эрүүл мэнд, соёлын үйлчилгээг чанартай, хүртээмжтэй хүргэх, төрийн үйлчилгээний ил тод байдлыг хангах, төрийн албан хаагчдыг чадваржуулж, тэдний ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр голлон анхаарч ажиллах талаар чиглэл өгсөн.

2021 оны 3 дугаар сарын 14-ний өдөр болсон хүчтэй шороон шуурганы улмаас аймгийн хэмжээнд 6000 гаруй мал хорогдож, нийтийн эзэмшлийн барилга байгууламжийн дээвэр, гадна фасад хууларч, 51 айлын гэр нурж, 17 гэр дахин ашиглагдахгүй болж, аймгийн хэмжээнд 760 гаруй сая төгрөгийн хохирол учраад байна. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга, аймгийн Засаг дарга, аймгийн Засаг даргын орлогч болон холбогдох албаны хүмүүс хүчтэй шороон шуурганы улмаас гамшигт өртсөн малчидтай уулзаж өвс, тэжээлийн тусламж үзүүллээ. Гамшгийн хохирлыг бууруулах чиглэлээр шат дараатай арга хэмжээ авч хэрэгжүүлсэн бөгөөд эхний ээлжид малчин өрхүүдэд аймгийн өвс тэжээлийн нөөцөөс 64 тонн өвс, 8.1тн тэжээл олголоо.

Аймгийн хэмжээнд 2021 он гарсаар коронавируст халдварын шинжилгээнд давхардсан тоогоор 7019 хүнийг шинжилгээнд хамруулснаас 3278 хүнийг ПГУ/PCR –ийн шинжилгээ, 3741 хүнийг түргэвчилсэн оношлуурын шинжилгээнд хамруулсан.

2021 оны 3 дугаар сарын 27-ны өдөр Сүмбэр суманд коронавируст халдварын 2 тохиолдол бүртгэгдсэнтэй холбогдуулан аймгийн Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн А/90 дүгээр захирамжаар өндөржүүлсэн бэлэн байдлын улбар шар түвшинд шилжиж, хот хоорондын хөдөлгөөн, худалдаа үйлчилгээний байгууллагын ажиллах цагийн хуваарьт хязгаарлалт тогтоолоо.

### ХОЁР. ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ, САНХҮҮГИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

2021 оны 3 дугаар сарын нийт татварын орлогын төлөвлөгөө 1 570 817 мянган төгрөг төвлөрүүлэхээс 1 699 900 мянган төгрөг төвлөрүүлж, 103.9 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс улсын төсвийн орлогын төлөвлөгөө 244 396 мянган төгрөг төвлөрүүлэхээс 244 400 мянган төгрөгийг төвлөрүүлж 100 хувь, сумын төсвийн орлогын төлөвлөгөө 203 797 мянган төгрөг төвлөрүүлэхээс 204 500 мянган төгрөг төвлөрүүлж 100.3 хувь, аймгийн төсвийн орлогын төлөвлөгөө 1 122 654 мянган төгрөг төвлөрүүлэхээс 1 251 000 мянган төгрөг төвлөрүүлж 111.4 хувийн гүйцэтгэлтэй байна.

2021 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар татвар төлөгч хуулийн этгээд нийт 636 болсон байна.

**Санхүүгийн хяналт аудитын чиглэлээр:** Сүмбэр, Шивээговь, сумын сум хөгжүүлэх сангийн 2021 оны 1, 2 дугаар сарын шилэн дансны цахим хуудсанд мэдээ оруулалтад хяналт шалгалт хийхэд нийт 4 зөрчил илэрсэн. Зөрчлийг арилгуулахаар хугацаатай албан бичиг өгч, зөвлөмж хүргүүлсэн.

2020 оны хяналт шалгалтаар тогтоогдсон нөхөн төлбөрийн актын үлдэгдэлтэй 5 байгууллагын нийт 9305.7 мянган төгрөгийн актыг төлүүлэхээр аймгийн прокурорын байгууллагатай хамтран ажиллаж байна.

Аймгийн нэгдсэн эмнэлгийн 2015-2017, 2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар тогтоогдсон нөхөн төлбөрийн актын үлдэгдэл 7952 мянган төгрөгийг барагдуулахаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт шилжүүлэв.

Илчлэг шивээ ОНӨААТҮГ, Талын илч ОНӨААТҮГ, Цөм сүрэг үржлийн төвд 2021 оны 1 дүгээр сарын шилэн дансны цахим хуудсанд мэдээ оруулалтад хяналт шалгалт хийхэд нийт 13 зөрчил илэрсэн бөгөөд зөрчлийг арилгуулахаар зөвлөмж хүргүүлсэн.

Аймгийн хэмжээнд төсвийн болон орон нутгийн өмчит 81 байгууллагын шилэн дансны хуулийн хэрэгжилт 2021 оны 2 дугаар сарын байдлаар 93.4 хувьтай байна.

**Нийгмийн даатгалын сангаас олгосон: Тэтгэвэр**

№	Төрөл	2020.03.25		2021.03.25	
		Хүний тоо	Тэтгэврийн дүн /мян.төг/	Хүний тоо	Тэтгэврийн дүн /мян.төг/
1	Өндөр настан	1758	2264243.0	1909	2686830.7
2	Хөгжлийн бэрхшээлтэй	356	453370.7	326	320973.7
3	Тэжээгчээ алдсан	138	132341.1	122	123630.1
4	Үйлдвэрлэлийн осол	29	61046.2	46	70609.3
<b>Нийт дүн</b>		<b>2281</b>	<b>2911001.0</b>	<b>2403</b>	<b>3202043.8</b>

**Нийгмийн даатгалын сангаас олгосон: Тэтгэмж**

№	Төрөл	2020.03.25		2021.03.25	
		Хүний тоо	Тэтгэмжийн дүн /мян.төг/	Хүний тоо	Тэтгэмжийн дүн /мян.төг/
1	ХЧТА тэтгэмж	215	21700.0	182	27369.6
2	ЖБА тэтгэмж	78	114510.0	98	188114.6
3	Оршуулгын тэтгэмж	16	16000.0	19	19000.0
4	ҮОМШӨ-ХЧТА	0	0	9	8412.9
5	Ажилгүйдлийн тэтгэмж	58	123520.0	45	72382.0
<b>Нийт дүн</b>		<b>367</b>	<b>275730.0</b>	<b>353</b>	<b>315279.1</b>

**Сайн дурын даатгал:**

Сайн дурын даатгалын хамрагдалт	2020.03.25	2021.03.25
Шинээр	78	89
Мөнгө тушаасан	481	389
Тушаасан мөнгөн дүн / мян төг/	65320.0	41304.6

**ГУРАВ. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД**

Архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд 1304 заалт, 13062 хүний нэр, 2213 байгууллагын нэр, 4071 газар зүйн нэр, 1678 хуудас баримт программд холбож, 1678 хуудас баримтыг засварлаж, 1678 хуудас баримт скайнердсан. Архивын баримтаас 6 иргэнд 19 лавлагаа мэдээлэл олгосон.

**Иргэний бүртгэлийн чиглэлээр:**

- Шинээр гадаад паспорт захиалсан - 16
- Иргэний үнэмлэх шинээр олгосон - 57
- Төрснөө бүртгүүлсэн хүүхдийн тоо - 24

- Гэрлэлт цуцлуулснаа бүртгүүлсэн тоо - 2
- Нас барсныг бүртгүүлсэн тоо - 6
- Өөр аймаг, хотоос шилжиж ирсэн нийт иргэн - 17
- Аймаг дотор шилжсэн иргэдийн тоо - 14
- **Эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр:**
- Үл хөдлөх хөрөнгийг анхны удаа баталгаажуулах бүртгэл - 5
- Газар өмчлөх эрхийг анхны удаа баталгаажуулах бүртгэл - 11
- Гэрээний бүртгэл - 48
- Барьцааны гэрээний бүртгэл - 162
- Эд хөрөнгөнд орсон өөрчлөлт, залруулга - 1

**Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр:**

- Шинээр байгуулагдсан хуулийн этгээдийн бүртгэл - 1
- Хуулийн этгээдийн бүртгэлийн өөрчлөлт - 4

**Архивын чиглэлээр:**

- Төрийн байгууллагад гаргасан лавлагаа, хуулбар - 7
- Хуулийн этгээдэд гаргасан лавлагаа, хуулбар – 23
- Иргэнд гаргасан лавлагаа, хуулбар – 124

Нийт 552 иргэнд төрийн үйлчилгээг үзүүлсэн.

**Цагдаагийн хэлтэс нь:** Тайлант сард иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас 111 гомдол, мэдээллийг хүлээн авч шалгаснаас гэмт хэргийн шинжтэй 19, зөрчлийн шинжтэй 92 гомдол мэдээлэл байна.

Ковид 19 цар тахлаас урьдчилан сэргийлэх бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан хорио цээрийн дэглэмийн үеэр байнгын болон явуулын 3 постод аймгийн Засаг дарга бөгөөд Онцгой комиссын даргын өгсөн үүрэг, чиглэлийн дагуу Онцгой байдлын газар, Цагдаагийн хэлтэс, Нэгдсэн эмнэлгийн алба хаагч нар хамтран 24 цагаар эргүүлийн үүрэг гүйцэтгэж байна.

Улсын болон орон нутгийн хэмжээнд зохион байгуулагдаж байгаа “Тээврийн хэрэгслийн яндангаас гарах утаа, дуу чимээ”, “Би...байна”, “Мөрөөдлийн шүхэр”, “Эко-2021” зэрэг нөлөөллийн арга хэмжээнүүдийн хүрээнд утаа ихтэй болон бүрэн бус тээврийн хэрэгсэлтэй замын хөдөлгөөнд оролцсон 171 жолоочийг 3 420 000 төгрөгөөр, техникийн хяналтын үзлэгт хамрагдаагүй 15 жолоочийг 750 000 төгрөгөөр торгож, захиргааны арга хэмжээ авлаа.

**Шүүхийн шинжилгээний алба нь:** Хэргийн газрын үзлэгт 15 удаа оролцсоноос хүний амь эрсэдсэн хэргийн газрын үзлэгт 4, зам тээврийн ослын 1, хулгайлах гэмт хэрэг 3, бусад хэргийн газрын үзлэгт 7 удаа оролцож, хэргийн газрын үзлэгийн болон эд мөрийн баримт, эрэн сурвалжлах, танин олуулах ажиллагаа, хэргийн газрын давтан үзлэг, нэгжлэг, цогцос задлан шинжлэх зэрэг ажиллагааны 299 кадр гэрэл зургийг боловсруулан холбогдох материалд хавсаргасан.

**Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар 425 дугаар нээлттэй хорих анги нь:** Хүмүүжигч нарыг Монгол бичгийн сургалтад цахимаар хамруулан Монгол бичгээр цэвэр бичих, хурдан унших зэрэг уралдааныг зохион байгуулан ажиллаж байна. Мөн гөлөм оёх сургалт, оёдлын сургалт, мужааны сургалтад нийт 14 хүмүүжигч хамрагдаж байна.

Аймгийн Улсын бүртгэлийн хэлтэстэй хамтран иргэний бичиг баримтын зөрчилтэй 20 хүмүүжигчийг нийт 600 000 төгрөгийн торгуулиас бүрэн чөлөөлсний үр дүнд бичиг баримтын зөрчилтэй хүмүүжигчийн тоо өмнөх сард 26 байсан бол 6 болж буурсан үзүүлэлттэй байна.

Тайлант сард төлбөрийн 158 гүйцэтгэх баримт бичгээс 24 гүйцэтгэх баримт бичгийн 2566319.8 мянган төгрөг төвлөрүүлэхээс 24 гүйцэтгэх баримт бичгийн 247137.8 мянган төгрөг төвлөрүүлж 15.19 хувьтай байна.

**Мэргэжлийн хяналтын газар нь:** Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх, халдвар хамгааллын дэглэмийг сахиулах зорилгоор худалдаа, үйлчилгээ, хоол үйлдвэрлэл үйлчилгээний 23 газарт төлөвлөгөөт бус шалгалт хийхэд давхардсан тоогоор 56 зөрчил илэрч, 34 зөрчлийг газар дээр нь арилгуулав.

Мөн эрүүл ахуй халдвар хамгаалал, хүнсний чанар, стандарт, боловсролын хяналтанд 33 аж ахуйн, нэгж байгууллагыг хамруулан зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, 54 зөрчил илэрч, 48 зөрчлийг газар дээр нь арилгуулав.

Эрүүл ахуй халдвар хамгаалал, эмчилгээний чанар стандарт, эм био бэлдмэлийн хяналтаар аймгийн Нэгдсэн эмнэлэг, Энхтусдэм өрхийн Эрүүл мэндийн төв, Шивээговь, Баянтал сумын эрүүл мэндийн төвүүдийн эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдалд дэмжлэгт хяналт хийж, эрүүл мэндийн төвүүдийн зохион байгуулалт, хүний нөөц, багаж тоног төхөөрөмжийн хангалт, эрүүл ахуй халдвар хамгааллын дэглэм мөрдөхтэй холбоотой 19 зөрчил илрүүлж, 8 зөрчлийг газар дээр нь арилгуулан, 3 байгууллагад 11 заалт бүхий улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлсэн.

Сүмбэр сумын 2 дугаар багийн нутаг дэвсгэрт байрлах түүхий эдийн цэгт үхсэн малын хүүр, сэг зэмийг худалдаж аваад байгаа тухай иргэний гомдлын дагуу төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийхэд 3 төрлийн зөрчил илрүүлж, тухай зөрчилд 6 заалт бүхий улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлж, үхсэн малын хүүр, сэг зэмийг устгуулж, Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжээр тухайн түүхий эдийн цэгийн 140м<sup>2</sup> талбайд халдваргүйтгэл хийлгэхэд нь хяналт тавьж, үхсэн малыг цаашид худалдаж авахгүй байхаар зөвлөгөө өгч ажиллав.

**Онцгой байдлын газар:** Тайлант хугацаанд гал түймрийн 1, гал түймрийн зөрчлийн 2, аюулт үзэгдлийн (шороон шуургатай холбоотой) 30, зам тээврийн ослын 1, газар хөдлөлтийн мэдээллийн 2 дуудлага бүртгэгдсэн байна.

Баянтал сумын 2 дугаар багийн нутаг дэвсгэр Хоёр толгой гэдэг газар /өргөрөг 46°44'57.19" уртраг 108°19'48.56"/ аймгийн төвөөс хойд зүгт 44 км-т, Баянтал сумын төвөөс хойд зүгт 22 км-т 2021.03.23-ны өдөр Улаанбаатарын цагаар 22:46 цагт 5.43 магнитудын, Баянтал сумын төвөөс хойд зүгт 17 км-т 3 дугаар сарын 24-ний өдөр 3.9 магнитудын хүчтэй газар хөдөлсөн мэдээллийг тухай бүр холбогдох албад, ард иргэдэд мэдэгдсэн. Газар хөдлөлтийн улмаас хүний амь нас эрсдээгүй, зарим барилгад цууралт өгснийг мэргэжлийн байгууллагууд шалгаж байна. байна.

Гамшгаас хамгаалах болон Гал түймрийн улсын хяналтын дүрэм, галын аюулгүй байдлын норм, нормативын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах төлөвлөгөөт хяналт шалгалтыг 3 дугаар сарын 9-17-ны өдрүүдэд Сүмбэр, Шивээговь сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг эм, ханган нийлүүлэх төв, эмийн сангуудад зохион байгуулан давхардсан тоогоор гал түймэр гарч болзошгүй 54 зөрчил илрүүлж, шалгалт хийх явцад газар дээр нь 14 зөрчлийг арилгуулж, Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага, танилцуулгыг холбогдох албан тушаалтанд хүргүүлэн ажиллав.

Галын аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор Сүмбэр сумын 1 дүгээр багийн гэр хороолол, дан байрны айл өрхөөр цахилгааны, галын аюулаас урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулан, 154 айл өрхөд хаврын хуурайшилтын үед үнс нурам ил задгай асгаж, болзошгүй гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, цахилгааны галын аюулаас урьдчилан сэргийлэх, сэрэмжлүүлэг заавар зөвлөгөө өгч, 94 зөрчил илрүүлснээс 25 зөрчлийг арилгуулж, 69 зөрчлийг арилгуулах талаар заавар зөвлөмж өгч, 230 иргэнд галын аюулаас урьдчилан сэргийлэх тараах материал өгсөн.

Коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр 3 дугаар сард Улаанбаатар хот болон бусад аймаг орон нутгаас ирсэн 144 иргэнийг гэр бүлийн хамт гэрийн ажиглалтад авч Онцгой байдлын газрын 22 алба хаагч өдөр бүр хяналт тавин ажиллаж байна.

**ДӨРӨВ. БОЛОВСРОЛ, СОЁЛ, ЭРҮҮЛ МЭНД,  
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД**

**Боловсролын чиглэлээр:** Мэргэжлийн багийн ахлагч нартай цахим хэлэлцүүлэг зохион байгуулж, теле хичээлийн агуулгаар оношлох үнэлгээ хийх удирдамж боловсруулж, мэргэжлийн багш нарт чиглэл өгч ажилласан.

Бага боловсролын хүрээнд 1-2 дугаар ангийн Монгол хэл, Математик, 3-5 дугаар ангийн Монгол хэл, Математик, Байгалийн ухааны хичээлээр оношлох үнэлгээг, теле хичээлийн агуулгын хүрээнд зохион байгууллаа.

Орон нутагт коронавируст халдварын тохиолдол илэрсэнтэй холбоотой аймгийн Засаг даргын 2021 оны

Багш нарын зайн сургалтын арга, технологийн шилдэг туршлагыг “Боловсролын хүрээлэн”-д хүргүүлж, харилцан туршлага солилцсон.

Сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаа эхэлсэнтэй холбогдуулан төрийн өмчийн 6, хувийн хэвшлийн 4 цэцэрлэгийн сургалт үйл ажиллагаа, халдвар хамгаалал, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлж буй ажил байдалтай танилцан, зөвлөмж зөвлөгөөг өгч ажиллалаа.

Аймгийн хэмжээнд хамран сургах тойргийн цэцэрлэгт хамрагдаагүй 5 настай хүүхдүүдийн судалгааг гаргаж, сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамруулах ажлыг зохион байгуулж байна.

Орон нутагт коронавируст халдварын тохиолдол илэрсэнтэй холбоотойгоор аймгийн Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн А/90 дүгээр захирамжаар сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг 2021 оны 3 дугаар сарын 29-ний өдрөөс 4 дүгээр сарын 11-ний өдрийг хүртэлх хугацаанд зогсоосон.

**Гэр бүл, хүүхэд, залуучуудын чиглэлээр:** Аймгийн Засаг даргын дэргэдэх “Залуучуудын хөгжлийн салбар зөвлөл”-ийн 2021 оны анхдугаар хурлыг 3 дугаар сарын 3-ны өдөр зохион байгууллаа.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дэргэдэх сэтгэл зүйн төвөөс 3 дугаар сарын 1-19-ний хооронд 14 хүнд сэтгэл зүйн ганцаарчилсан зөвлөгөө өгсөн.

Зорилтот өрхийн гишүүдэд “Хүүхэд хүмүүжлийн эерэг арга”, “Гэр бүлийн харилцаа”, “Стресс уур бухимдлаа зөв аргаар тайлах”, “Гэр бүлийн үнэ цэнэ” сэдвүүдээр 4 удаагийн ганцаарчилсан сургалт, 2020 оны 3 дугаар сарын 16-ны өдөр зорилтот өрхийн 24 иргэнд “Хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга” сэдвээр сургалт зохион байгууллаа.

Өсвөр үеийнхэнд үе тэнгийнхний дарамтаас урьдчилан сэргийлэх зорилгоор “Үе тэнгийн ментор” бэлтгэх 2 өдрийн сургалтыг Дэлхийн зөн ОУБ, Монголын урлагийн сэтгэл заслын мэргэжлийн холбоотой хамтран зохион байгууллаа. Тус сургалтад аймгийн Ерөнхий боловсролын сургуулиудын 9-11 дүгээр ангийн 24 сурагч оролцсон.

**Соёл, урлагийн чиглэлээр:** Дуу бүжгийн Боржигин чуулга, Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр болон Монгол цэргийн өдрийг тохиолдуулан урлагийн тоглолт зохион байгуулсан.

Нийтийн номын сангаас иргэд, хүүхэд багачуудад зориулан сургамжит өгүүллэг, танин мэдэхүйн өгүүллэг тууж, яруу найраг, үлгэрийн номыг цахимаар уншигчдад хүргэсэн бөгөөд нийт 17822 уншигчдад хүрсэн.

**Эрүүл мэндийн чиглэлээр:**

Үзүүлэлт	2020 оны 03 сарын 20-ны байдлаар	2021 оны 03 сарын 20-ны байдлаар
Төрсөн эх	102	89
Гэрийн төрөлт	0	1

Амьд төрсөн хүүхэд	103	91
Амьгүй төрөлт	0	0
Нас баралт	17	17
Эмнэлгийн нас баралт	1	5
Хоног болоогүй нас баралт	0	3
0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	0	0
1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	2	0
Эмнэлгээс гарсан хүний тоо	1319	617
Амбулаторийн үзлэг	25619	21465
Халдварт өвчин	32	7

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн 100 ортой шинэ барилгад “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах” улсын комисс 2021 оны 3 дугаар сарын 5-ны өдөр ажиллаж, ажлын гүйцэтгэлтэй танилцан, үүрэг даалгавар өгч, барилгыг байнгын ашиглалтад хүлээн авахаар шийдвэрлэсэн.

Эрүүл мэндийн яамнаас хуваарилсан аймгийн Нэгдсэн эмнэлгийн тусламж үйлчилгээнд шаардлагатай 45.7 сая төгрөгийн үнэ бүхий 3 ширхэг амьсгалын аппаратыг хүлээн аваад байна.

2021 оны 3 дугаар сарын 23-ны өдөр Сүмбэр сумын хөдөөгийн багийн гамшигт үзэгдэлд өртсөн 37 өрхийн 143 иргэнд явуулын амбулаториор 20 иргэнд тусламж үйлчилгээг үзүүлэн, 92000 төгрөгийн эм, тариа олгож, 9 хүүхдийг товлот вакцинд хамруулсан.

Улаанбаатар хотод коронавируст халдварын тохиолдол нэмэгдэж байгаатай холбоотойгоор орон нутгаас хүн хүч дайчлан ажиллах ажиллагаанд 5 хүний бүрэлдэхүүнтэй багийг ажиллуулахаар томилсон.

Эрүүл мэндийн яамны санаачилгаар Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын дэмжлэгтэйгээр хэрэгжиж байгаа “Говьсүмбэр аймгийн хүн амд үзүүлэх эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний чадавхыг сайжруулах нь” төслийн хүрээнд өрх, сумын эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд нэн шаардлагатай 7 нэр төрлийн 30.7 сая төгрөгийн багаж, төхөөрөмжийг хүлээн авлаа.

Сүмбэр суманд коронавирусийн 2 тохиолдол бүртгэгдсэнтэй холбоотойгоор ойрын болон дам хавьтлын 670 хүнээс PCR шинжилгээ авч, шинжилгээний хариу бүгд сөрөг гарсан. Голомт болон хавьтал тогтоох ажиллагаа үргэлжилж байна.

**Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний чиглэлээр:** Ажил олгогч аж ахуй нэгж байгууллагаас 30 сул, чөлөөтэй ажлын байрны захиалгыг авч, 10 иргэнийг байнгын ажлын байранд, 4 иргэнийг түр ажлын байранд зуучилсан.

Ажил олгогч нарт Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, тогтоомж, хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний талаарх мэдээ мэдээллийг хүргэж, шинээр бий болсон 18 байнгын ажлын байрыг мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэн.

2021 оны 3 дугаар сарын байдлаар нийгмийн халамжийн сангаас дараах хөнгөлөлт, үйлчилгээнүүдийг үзүүллээ. Үүнд:

- Нийгмийн халамжийн тэтгэвэр 252 хүнд 159.8 сая төгрөг
- Нөхцөлт мөнгөн тэтгэмж 246 хүнд 68.5 сая төгрөг
- Амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж 138 хүнд 44.7 сая төгрөг
- Ахмад настнуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж 473 хүнд 6.3 сая төгрөг
- Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлсэн хөнгөлөлт, тусламж 48 хүнд 2.9 сая төгрөг
- Хүнс тэжээлийн дэмжлэг туслалцаа 671 хүнд 15.2 сая төгрөгийг тус тус зарцуулсан.

Нийгмийн халамжийн тэтгэврийг Ehalamj.mn цахим системрүү хөрвүүлэх, үйлчилгээг цахимаар дамжуулан олгох бэлтгэл ажлын хүрээнд 160 гаруй иргэдийн дансыг тохируулж, 5

иргэний овог нэр зөрүүтэй байсныг засаж, 2, 3 дугаар сарын олголтыг 3 дугаар сарын 15-ны өдөр олгосон.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын хурлыг 2021 оны 3 дугаар сарын 18-ны өдөр зохион байгуулж, 1 хүүхдийн асуудлыг шийдвэрлэсэн.

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг гэрээлэн гүйцэтгэх аж ахуй, нэгж, төрийн бус байгууллагын сонгон шалгаруулалтыг зарлаж, шаардлага хангасан материал ирүүлсэн “Энхбилэг” эмнэлэг, “Гэгээн Мандарваа” уламжлалт сэргээн засах эмнэлэгтэй хамтран ажиллах гэрээ байгуулахаар ажиллаж байна.

### ТАВ. ХӨДӨӨ АЖ АХУЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

2021 оны 3 дугаар сарын 14-ний өдөр 20-27м/с, хүчтэй үедээ 29.2 м/с-ийн хурдтай шороон шуурга шуурч, мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлд ихээхэн хэмжээний хохирол учруулаад байна. Шороон шуурганы хохирлын хэмжээг 506.0 сая төгрөг гэж тооцоолон журмын дагуу 48 цагийн дотор багтаан мэдээлсэн. Одоо хохирол тооцох журмын дагуу нарийвчилсан үнэлгээг тогтоох ажил хийгдэж байна.

Аймаг, сумдын өвс, тэжээлийн аюулгүйн нөөцөөс давхардсан тоогоор 713 малчин өрхөд 6971 боодол өвсийг хөнгөлөлттэй үнээр олгосон.

Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр 300 малчин өрхийг тусламжид хамруулахаар судалгааг гарган нэгтгэж, Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлсэн.

Аймгийн хэмжээнд 2021 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хойш өссөн дүнгээр 8237 толгой мал хорогдоод байна.

Малын зүй бус хорогдол:

№	Сумын нэр	Оны эхэнд /малын тоо/	Хорогдсон мал						Оны эхний малд эзлэх хорогдлын хувь
			Бүгд	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа	
1	Баянтал	69705	867		26	26	191	624	1.2
2	Сүмбэр	322066	5895	2	34	113	3066	2680	1.8
3	Шивээговь	59226	1475		32	60	574	809	2.5
	<b>Дүн</b>	<b>450997</b>	<b>8237</b>	<b>2</b>	<b>92</b>	<b>199</b>	<b>3831</b>	<b>4113</b>	<b>1.8</b>

### Аймгийн төвийн захууд, томоохон худалдааны төвүүдийн хүнсний бараа бүтээгдэхүүний үнийг өнгөрсөн сарын үнэтэй харьцуулан гаргасан 2021 оны 03 дугаар сарын үнийн мэдээ

Зах зээлд худалдаалагдаж буй зарим хүнсний бараа бүтээгдэхүүний үнэ өнгөрсөн сараас 20-1000 төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Тухайлбал: үхрийн мах /ястай, цул/ 1000 төгрөгөөр, Хонины мах /ястай, цул/ 1000 төгрөгөөр, адууны мах /ястай, цул/ 500-1000 төгрөгөөр, ямааны мах /ястай, цул/ 1000-1500 төгрөгөөр, өндөг 20 төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Бусад бараа бүтээгдэхүүний үнэ тогтвортой байна.

№	Бараа бүтээгдэхүүн		Дээд үнэ төг	Доод үнэ төг	Өссөн буурсан /2-р сараас /
1	Үхрийн мах	Ястай	10500	1000	+1000
		Цул	13000	12000	+1000
2	Хонины мах	Ястай	8500	8000	+1000
		Цул	10500	10000	+1000

3	Адууны мах	Ястай	6500	6000	+500
		Цул	8500	8000	+1000
4	Ямааны мах	Ястай	7000	6500	+1000
		Цул	9500	8500	+1500
5	Тахианы мах	Гуя	10500	7900	-
		мөч	8200	7900	-
6	Лууван	Монгол	2000	1100	-
		Хятад	-		
7	төмс	Монгол	1300	900	-
		Хятад	-		
8	Байцаа	Монгол	2000	1800	-
		Хятад	-		-
9	чинжүү	Монгол	8500	7000	-
		Хятад	7500	4500	
10	Манжин	Монгол	2000	1500	
		Хятад	-		-
11	Сонгино бөөрөнхий	Монгол	4400	2300	-
		Хятад	-	1400	-
12	Улаан лооль	Монгол	7500	5500	-
13	Өргөст хэмх	Монгол	7500	6500	-
14	Элсэн чихэр	Монгол	3000	2300	-
15	Будаа	Цагаан задгай кг	3000	2400	-
		Шар слава кг	3500	3000	-
		Гурвалжин будаа кг	3800	2200	-
16	Сүү	Задгай	3450	3000	-
		Сүү ХХК 0,5л	-		
		Сүү ХХК 1л	3200	2900	-
17	Тараг	Задгай	2200	2000	-
		Сүү ХХК 1л цөцгийтэй тараг	4800	3800	-
18	Талх	Чойр талх	1200	1150	-
19	Өндөг	Монгол	550	500	+20
20	Алтан тарианы гурил	Задгай дээд	1520	1480	
		Задгай 1-р зэрэг	1210	1100	-
		Задгай 2-р зэрэг	1000	950	-
		Савласан д/дээд /	2400	2300	-
		Савласан дээд	2200	2100	-
		Савласан 1-р зэрэг	1400	1300	-
		Савласан 2-р зэрэг	1500	1450	-
21	Ургамлын тос	Олейна	5500	5200	-
		Алтан	4500	4500	-
22	Гоймон	Алейка	1800	1600	-
		А/тариа савхан	1100	950	-



Мал эмнэлгийн газраас аймгийн хэмжээнд зүй бусаар хорогдсон малын сэг зэмийн устгал хийсэн цэгийн халдваргүйтгэлийн ажлыг хийж байна Одоогийн байдлаар Сүмбэр сум бод-367, бог-6768, зээр-461, Баянтал сум бод-298, бог-1766, зээр-12, Шивээговь сум бод-92, бог-2451, зээр-54 амьтан-3 нийт 11672 ширхэг сэг зэм устгаж 1111 м<sup>2</sup> талбайд ариутгал халдваргүйтгэл хийв.

Мал эмнэлгийн хяналтын ажлын хүрээнд Сүмбэр сумын 33 өрх, Дундговь аймаг- 8 өрх, Өвөрхангай аймаг- 4 өрх, Баянхонгор аймаг- 1 өрх, нийт 46 өрхийн малчинтай уулзаж, “Мал амьтны эрүүл мэндийн тухай хууль”, “Малын эмийн зохистой хэрэглээ” болон “Мал амьтны сэг зэм устгах заавар”-ын талаар 138 ш гарын авлага тараасан.

Аймгийн “Малын эрүүл мэнд дэд хөтөлбөр”-ийн хүрээнд нийгэм, эдийн засагт учруулах хор хөнөөл ихтэй адууны нийлүүлгийн өвчний шинжилгээг элиза аргаар 45 өрхийн 438 дээжид, адууны халдварт цус багадах өвчний нэвчин тунадасжуулах урвалын шинжилгээг 66 өрхийн 800 дээжид, Хавсран холбох урвалын шинжилгээг 35 өрхийн 460 дээжид тус тус хийж гүйцэтгэв. Адууны нийлүүлгийн өвчний шинжилгээгээр 22 өрхийн 29 сорьц эерэг, 44 өрхийн 409 сорьц сөрөг дүн үзүүлсэн. Ям болон адууны халдварт цус багадах өвчний шинжилгээгээр бүх сорьц сөрөг дүн үзүүлсэн.

### **ЗУРГАА. БАЙГАЛЬ ОРЧИН, ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭ, ДЭД БҮТЦИЙН САЛБАРЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД**

**Байгаль орчны чиглэлээр:** Байгаль орчин, аялал жуулчлалын газраас дархан цаазат ховор амьтан болох аргаль хонинд зориулан, биотехникийн арга хэмжээг тусгай хамгаалалттай Чойрын Богд ууланд 3 дугаар сарын 12-ны өдөр авч хэрэгжүүлж, 50 боодол өвс, 16 ширхэг ашиг долооц бэлтгэж, зэрлэг амьтдын байршиж буй 4 байршилд тараан байрлуулсан.

Агаарын чанарын хяналтыг хийж 3 дугаар сарын 1-18-ны өдрийн дээжид шинжилгээ хийхэд дунджаар азотын давхар исэл (NO<sub>2</sub>) 0.015 мкг/мг, сарын хүлцэх агууламж хэмжээ 0.050 мкг/мг, хүхэрлэг хийн давхар исэл (SO<sub>2</sub>) 0.027 мкг/мг байгаа нь хүлцэх агууламжаас хэтрээгүй байна.

**Газрын харилцаа, барилга, хот байгуулалт, хөрөнгө оруулалтын талаар:** Газрын төлбөрийн орлогоор аймгийн хэмжээнд нийт 44 758 543 төгрөг төвлөрсөн байна. Үүнд: Аймгийн дансанд 43 433 930 төгрөг, Сүмбэр сумын дансанд 720 000 төгрөг, Баянтал сумын дансанд 589 223 төгрөг, Шивээговь сумын дансанд 15 390 төгрөг тус тус төвлөрсөн.

Улсын хэмжээнд хаягжуулалтын ажлыг эрчимжүүлэх үүрэг чиглэл өгсний дагуу “Хаягийн мэдээллийн санд мэдээлэл оруулах, засварлах ажлыг эрчимжүүлэх ажлын төлөвлөгөө”-г батлан, мэдээллийн санд хаягийг засварлах, оруулах ажлыг хуваарь гарган зохион байгуулж, 96 хувийн гүйцэтгэлтэй байна.

№	Хаягийн мэдээллийн санд мэдээлэл оруулсан байдал				
	Сумын нэр	Нэгж талбар	Орц, гарц	Гудамж	Барилга
1	Сүмбэр	7003	7577	413	1636
2	Баянтал	1650	1654	157	142
3	Шивээговь	1968	2015	119	120
<b>Нийт дүн</b>		10621	11246	689	1898

2021 оны 3 дугаар сарын 14-ний өдөр болсон хүчтэй шороон шуурганы улмаас барилга, байгууламж, нийтийн эзэмшлийн талбайд учирсан хохирлыг урьдчилсан байдлаар гаргахаар Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Мэргэжлийн хяналтын газар, Онцгой байдлын газрын холбогдох албан хаагчдаас бүрдсэн ажлын хэсэг байгуулагдаж, сумдын Засаг даргын Тамгын газар, Сууц өмчлөгчдийн холбоо, ашиглагч байгууллагуудтай хамтран судалгааг гаргаад байна. Урьдчилсан тооцоо судалгаагаар 22 барилга, байгууламжид нийтдээ 170 гаруй сая төгрөгийн хохирол учирсан гэж тооцоолоод байна.

**Худалдан авах ажиллагааны талаар:** Төсвийн ерөнхийлөн захирагчаас 2021 онд нийт 1 640 405 5 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 22 бараа, ажил, үйлчилгээ худалдан авч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Үүнээс 11 тендер шалгаруулалтыг цахим хэлбэрээр зарлаад байна.

3 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар Орон нутгийн хөрөнгө оруулалтаар нийт 15 ажил хийгдэхээр төлөвлөснөөс 7 ажлын тендер шалгаруулалтыг, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар нийт 5 ажил хийгдэхээр төлөвлөснөөс 4 ажлын тендер шалгаруулалтыг, Авто замын сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх 1 ажил төлөвлөснөөс 1 ажлын тендер шалгаруулалтыг тус тус зарлаад байна. Мөн Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар хийгдэх 1 ажил төлөвлөснөөс 1 ажлыг зарлаад байна.

Зарлагдсан тендерийн урилгуудыг “Монголын үнэн” сонин болон [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn), [govisumber.gov.mn](http://govisumber.gov.mn) сайтуудад тухай бүр нийтэлж, тендер шалгаруулалтыг 100 хувь цахим хэлбэрээр явуулж байна.

**Орон нутгийн өмчийн талаар:** 43 хуулийн этгээдийн өмч эзэмшүүлэх гэрээг дүгнэхээс 27 хуулийн этгээдийн гэрээг дүгнээд байна. 2021 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар түрээсийн орлого өссөн дүнгээр 4.5 сая төгрөг аймгийн дансанд төвлөрсөн.

### **ДОЛОО. СУМ ОРОН НУТГИЙН ТАЛААР**

**Баянтал сум:** 3 дугаар сарын 14-ний өдөр хүчтэй шороон шуурганы улмаас эрлийн баг 7 хүнийг эрэн хайх ажиллагааг зохион байгуулж, эсэн мэнд олсон бөгөөд 12 малчны гэр, хашаа, саравч нь шуурганд өртсөн болон гэр оронгүй болсон 5 өрхөд гэр олгох асуудлыг шийдвэрлэсэн.

Малын сэг зэмийн устгалд 12 иргэн ажиллаж, 375 тн сэг зэмийг устгалд оруулсан.

Сумын хэмжээнд 1007 толгой мал төллөсөн. Үүнд: унага 1, тугал 7, хурга 808, ишиг 149 байна. Төлийн бойжилт 95.4 хувьтай байна.

2021 оны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр “Цэцэрлэгийн хүүхдийн модон ширээ, сандал”, “Цусны шинжилгээний анализатор” худалдан авах 2 тендер шалгаруулалтыг зохион байгуулж, гэрээ байгуулах эрх олгоод байна.

**Шивээговь сум:** Сумын 22-р дугаар зөрлөг дээр 1 пост ажиллуулж 2 дугаар сарын 24-3 дугаар сарын 24-ний өдрийн хооронд давхардсан тоогоор сумаас гарсан 3400 тээврийн хэрэгсэл, 9200 зорчигч, сумруу орсон 3600 тээврийн хэрэгсэл 10800 зорчигч, дамжин өнгөрсөн 93 тээврийн хэрэгсэл 240 зорчигч хөдөлгөөнд оролцсон байна.

Сумын шуурхай штабаас Улаанбаатар хот болон өөр аймаг орон нутагруу зорчих зөвшөөрлийг 44 иргэнд олгоод байна.

Сумын Засаг даргын А/27 дугаар захирамжаар “Цэргийн бүртгэл явуулах тухай” ажлын хэсэг томилогдон Цэргийн шинэчилсэн тоо бүртгэлийн ажлыг 2021 оны 3-р сарын 1-12-ны өдрүүдэд зохион байгуулж, 40 хувийн гүйцэтгэлтэй ажилласан байна.

Сумын Засаг даргын 2020 оны А/40 дүгээр захирамжаар “Газар зүйн нэрийн салбар зөвлөл байгуулах тухай” ажлын хэсэг томилогдон сумын 1, 2-р багт нэр өгөх ажлыг зохион байгуулж, саналын хуудсаар нийт 168 иргэнээс, цахимаар 38 иргэнээс санал ирүүлсэн.

Цар тахлын үед багийн иргэдийн нийтийн хурлыг хуралдуулах боломжгүй байгаа тул багийн Иргэдийн Нийтийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцэн иргэдээс ирүүлсэн саналыг газар зүйн нэрийн салбар зөвлөлийн ажлын хэсгээр хэлэлцүүлэн нэрсийг тодруулж сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 74 дүгээр тогтоолоор 1 дүгээр багийг Бэхт, 2 дугаар багийг Нэрт гэж нэрлэхээр аймгийн Засаг даргад уламжлаад байна.

3 дугаар сарын 24-ний өдрийн байдлаар ингэ 6, ямаа 743, хонь 824, үнээ 17, нийт 1590 мал төллөж, 1598 төл бойжиж, 3 тугал, 328 хурга, 98 ишиг, нийт 429 төл хорогдсон байна.

Сумын Засаг даргын А/29 дүгээр захирамжаар “Сэг зэм устгах” ажлын хэсгийг 8 хүний бүрэлдэхүүнтэй томилон сэг зэм устгалын ажлыг “Хийморь Алтай групп” мал эмнэлгийн нэгж хамтран 2021 оны 3 сарын 4-6-ны өдрүүдэд зохион байгуулж, нийт 2630 мал, амьтны сэг зэмийг булж, устгаж, 6 цэгт ариутгал халдваргүйжүүлэлт хийсэн

Шивээговь сумын 2021 оны “Орон нутгийн хөгжлийн сан”-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “Цагдаагийн эргүүлийн автомашин худалдан авах” ажлын нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерийг харьцуулалтын аргаар зохион байгуулж “Очирт хөрс” ХХК-г сонгон шалгаруулж гэрээ байгуулах мэдэгдлийг хүргүүлээд байна.

Суманд “Замын тэмдэг тэмдэглэгээг сайжруулах” ажлын шууд худалдан авалтын сонгон шалгаруулалтад “Их-Эффект” ХХК шалгарч 4 250 000 төгрөгийн гэрээг байгуулаад байна.

**Сүмбэр сум:** 2021 оны 3 дугаар сарын 14-ний өдөр болсон цаг агаарын аюулт үзэгдлийн улмаас шуурганд төөрч малтайгаа уруудсан 5 иргэнийг эрэн хайх ажлыг зохион байгуулж, Сүмбэр сумын Засаг даргын Тамгын газраас эрлийн баг гарган ажиллалаа. Мөн сумын төвд шуурганы улмаас гэр нь нурсан 8 дуудлагаар сумын Засаг даргын Тамгын газрын албан хаагчид шаардлагатай тусламжийг үзүүлсэн.

Сумын 2021 оны ОНХСангийн хөрөнгөөр хийгдэх хог хаягдал тээвэрлэх шахдаг авто машин худалдан авах нээлттэй тендерийг 3 дугаар сарын 5-ны өдөр, иргэний танхимд суудлын авто машин нийлүүлэх, худалдан авах харьцуулалтын тендерийг 3 дугаар сарын 8-ны өдөр тус тус цахимаар зарлаад байна.

## **ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**